

Нийгмийн тухай мэдлэг

БАГШ:Д.ОЮУН

Бүлэг 1: Нийгмийн тухай

Бүлгийн зорилго: Нийгмийн бүлэг, бүтэц, нийтлэг, түүний төрөл нийгмийн анги давхраа болон угсаатан түүний төрлийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцан мэдлэг хуримтлуулах, мэдлэг бататгах.

Сэдэв 2: Нийгмийн бүтэц

Сэдвийн зорилго: Нийгмийн бүтэц, социал статус, социал үүрэг, төрөлх ба олдмол статусын талаар болоод нийгмийн бүлэг, институтын буюу байгууллагын талаар болон нийгмийн анги, давхраажилт, угсаатны хэлбэрийн тухай цэгцтэй мэдлэг эзэмшихэд оршино.

Түлхүүр үгс:

- Социал бүтэц
- Социал статус
- Социал үүрэг
- Төрөлх статус
- Олдмол статус
- Социал бүлэг
- Нийгмийн институт
- Нийгмийн давхраажилт
- Угсаатан
- Гэрлэлт

Нийгмийн бүтэц

Нийгмийн тогтолцоо нь тодорхой бүтэцтэй. Нэг талаас улс төр, эдийн засаг, соёл зэрэг үндсэн элементийн хоорондын харилцаа буюу макро түвшиний бүтэцтэй, нөгөө талаас өөр хоорондын харилцан үйлдэл, хамааралд оршин хөгжигч статус, үүрэг, хэм хэмжээ, үнэт чанар бүхий хувь хүн, нийгмийн бүлэг, институт хоорондын харилцаа буюу социал түвшиний бүтэцтэй хэмээн ерөнхийд нь 2 ангилдаг.

Хүний гарал үүслийн талаарх үзэл онол:

Хүн хэрхэн үүссэн бэ?	Үзэл онолын төлөөлөгчид
Байгалийн хөгжилийн бүтээгдэхүүн	Шинжлэх ухааны үзэл, онол Ж.Ламарк, Ч.Дарвин, Ф.Энгельс
Бурханы бүтээл	Шашны номлол, сургаал Христос, Лал, Будда
Харь гарагийнхны туршилтын үр дүн	Таамаглал үлгэр домгын төсөөлөл
Ямар нэг амьтнаас төрсөн, амьтны үр хөврөл	Таамаглал үлгэр домгын төсөөлөл

Социал\нийгмийн\ бүтцийг бүрдүүлж буй үндсэн элементүүд:

1. Социал статус
2. Социал үүрэг
3. Социал бүлэг
4. Социал институт
5. Нийгмийн нийтлэгүүд



1. Социал статус \хүний статус\

Хүний статус гэдэг нь хүний нийгэмд эзлэх байр суурь болон эрх, үүргийн нэгдлийг илэрхийлсэн ойлголт юм. \Байр суурь нь тодорхой эрх, үүрэгтэй холбогдохоороо СТАТУС гэж нэрлэгддэг.\

Төрөлх статус	Тодорхой нэг хүний өвөрмөц авьяас чадвар буюу өөрт нь төрөлхөөс заяагдмал статус. \яс үндэс, хүйс, овог нэр, төрсөн газар\
Олдмол статус	Хүн өөрийнхөө хичээл зүтгэл, хүчин чармайлтаар олж авдаг статус. \олж авахын тулд аливаа нэг зүйлийг хийх ёстой\
Мастер статус	Бусдаасаа давамгайлсан, хүний нийгэм дэхь ерөнхий байр суурийг тодорхойлсон статус.
Гол статус	Тухайн хүний эрхлэн буй ажил.



2. Социал үүрэг

Социал үүрэг

Статусаар нөхцөлдөн тухайн хүнээс хүлээж байгаа зан төлөв, үйл үйлдлийг үүрэг гэнэ.

Албан үүрэг:

Хуулиар зохицуулагддаг

Албан бус үүрэг:

Тухайн хүний нийгэмшлийн илрэл болж байдаг



2. Социал үүрэг

Социал үүрэг гэдэг нь хүмүүсийн олж авч буй байр суурь буюу статусаас хүсэн хүлээж байгаа зүйл юм. \Жишээ: Багш хүн гавь нартаа хангалттай мэдлэг чадвар олгох, цагдаа иргэдэд аюул занал учирсан үед зохих арга хэмжээ авч чадах ёстой гэж бид хүсэн хүлээж байдаг.\

Энэ үүднээс бие хүнийг үүргийн цогц гэж үздэг.

Хүн бүр амьдарч буй нийгмэ, бүлэгтээ янз бүрийн үүрэг гүйцэтгэж байдаг. \Хувь хүн тодорхой нөхцөлд аав, найз, захирал гэх мэт\

Эдгээр үүргийнхээ нэгийг биелүүлээгүй цагт гомдож уурлах, гайхан бухимдах төдийгүй хоорондын харилцаанд ч өөрчлөлт орно.

Тухайн статуст тохирох эдгээр үүргийн цогцыг үүргийн тогтолцоо гэнэ.



2. Социал үүрэг

Америкийн судлаач Т.Парсонс болон түүний нөхөд \1951\ аливаа үүргийн шинжийг системчилэх явцдаа 5 зүйлээр тодорхойлж болно хэмээсэн байдаг.

Сэтгэл хөдлөл бүхий:

Өвчин зовлон, үхэл хагацлын үед сэтгэл хөдлөлөө чанга барьж гүйцэтгэхийг шаардаж байхад гэр бүл найз нөхөд энэ байдлыг хангаж чаддаггүй.

Олж авах арга:

Хүүхдийн, насанд хүрэгчидийн зэрэг үүрэг өгөгдсөн статусаар нөхцөлдсөн байдаг.

Хэмжээ:

Зарим үүрэг нь хүмүүсийн харилцан үйлчлэлийн тодорхой хэмжээгээр хязгаарлагддаг.

Хэлбэршсэн:

Зарим үүрэг нь тогтсон дүрмийн дагуу хэрэгждэг.

Сэдэл:

Үүрэг болгон янз бүрийн сэдлээр нөхцөлдөнө.

3. Социал бүлэг \нийгмийн бүлэг\

Нийгмийн бүлэг гэдэг нь ижил хэм хэмжээ, үнэт зүйл бүхий, хоорондоо ухамсартайгаар харилцдаг, тухайн бүлэгт багтаж байгаагаа ухамсарладаг, бусад хүмүүс ч тус бүлгийн гишүүн гэж үздэг хүмүүсийн цогцыг хэлдэг.

Бүлгийн шинжүүд

Бүлгийн эхний гол шинж нь гишүүдийн хооронд харилцан үйлдэл хийх тодорхой арга юм. Хоёрдах чухал шинж бол гишүүнчлэл юм. Мөн бүлэг нь бусдын нүдээр харахад өөрийн гэсэн онцлог, адилтгалтай.

Бүлгийн ангилал

Хувь хүний онцлогт тулгуурласан шууд болон шууд бус харилцан үйлчлэлд орж байгаа цөөн тооны хүмүүсээс анхдагч бүлэг үүснэ. Сэтгэл хөдлөлийн хэврэг харилцаа тогтсон, харилцан үйлчлэл нь тодорхой зорилгод хүрэхэд захирагдаж байгаа бүлэг хүмүүсээс бүрэлддэг анхдагч бүлгээс ялгагдах онцлогтой хоёрдогч бүлэг үүснэ.

Бүлгийн чиг үүрэг

Бүлэг бол хүнийг оролцуулан хамгийн сайн зохион байгуулагдсан хүн төрөлхтөний амьд үлдэх үндэс юм. Бүлэг нь хувь хүнийг нийгэмшүүлэхээс гадна –Гүйцэтгэгч, -Илэрхийлэгч чиг үүрэг гүйцэтгэнэ.

4. Социал институт \байгууллага\

Нийгмийн тодорхой хэрэгцээг хангах зорилго, чиг үүрэгтэй үйл ажиллагааг тустай стандарт мөрдөж, эрх зүйн тодорхой хэм хэмжээг хэрэгжүүлдэг байгууллага, хүмүүс, тэдгээрийн зан үйлийн цогц юм.

Нийгмийн ноён нуруу, нийгмийн барилга хэмээн үзэж болох тулгуур ойлголт юм.

Нийгмийн амьдралын хүрээ болгон бүтэцлэг шинжтэй байхын хамт, өөр өөрийн үндсэн үүрэгтэй, хүмүүсийн янз бүрийн чухал суурь хэрэгцээг хангаж байдаг. Энэхүү нийгмийн чухал хэрэгцээнүүдийг хангах, нийгмийн хэм хэмжээг зохицуулах чиг үүрэгтэй тохируулагч байгууллага нь нийгмийн институтууд юм.

4. Социал институт \байгууллага\

Институтууд	Ямар хэрэгцээг хангах	Үндсэн үүргүүд	Биет элементүүд
Гэр бүлийн	Үр удмаа нөхөн үйлдвэрлэх, өсгөх, хүмүүжүүлэх, халамжлах	Эцэг, эх, хүүхэд	Орон сууц
Улс төрийн	Хууль дүрэм ба хэм хэмжээнүүдийг(стандарт) дэмжих	Хууль, тогтоомж, эрх зүйн субъект	Нийтийн барилга байгууламж, байр сууц
Эдийн засгийн	Хоол хүнс, хувцас хэрэглэл, байр орон сууц олох	Ажил олгогч, хөлсний ажилчин, худалдагч, худалдан авагч	Фабрик, бичиг хэрэг, дэлгүүр гэх мэт
Боловсролын	Хүмүүсийг нийгэмшүүлэх ба суурь үнэт зүйл, дадлага, практикт суралцуулах	Багш, шавь	Дунд, их, дээд сургууль, коллеж, сурах бичиг
Шашны	Сүм хийдийн харилцаа, дэг ёст үйлчлэх, шүтлэг бишрэлийг гүнзгийрүүлэх	Хамба, гэсгүй\дэг сахиулагч\	Сүм хийд, дуган

5. Нийгмийн нийтлэгүүд, түүний төрөл

Амьдралын нөхцөл, хэв маяг, ухамсар, нийгмийн хэм хэмжээ, үнэлэмж, сонирхол зэргээрээ ямар нэг хэмжээнд адил төстэй хүмүүсийн харьцангуй тогтвортой цогц нэгдлийг нийгмийн нийтлэг гэнэ.


Нийгмийн нийтлэгийг хүмүүс зориудаар бий болгодоггүй. Түүхэн хөгжилийн явцад өөрөө аяндаа үүсэн төлөвшидөг. Янз бүрийн нөхцөл байдал, цаг үед, янз бүрийн хөрс сууринд олон төрлийн нийтлэг төрж бий болжээ.

- Үйлдвэрлэлийн нөлөөгөөр \нийгмийн бүлэг, анги, давхраа, мэргэжил...\
- Угсаа гарал, үүслийн шинжээр \угсаатан, ард түмэн...\
- Хүн ам зүйн, жам ёсны хүчин зүйлээр \нас, хүйс, нутаг...\
- Санамсаргүй нэгдсэн бүлгийн холбоогоор \хөл бөмбөгийн хөгжөөн дэмжигчид...\




Дэд сэдэв: Нийгмийн давхраажилт





. Нийгмийн давхраажилт


- Энэ ойлголт социологид нэгэн нийгмийн гишүүдийн хоорондох шаталсан тэгш бус байдлын бүтцийг илэрхийлдэг. Ингэхлээр давхраажилт гэдэг бол тэгш бус байдал үе дамжин уламжлагдаж буй аргатай холбогдож үүний үр дүнд янз бүрийн давхраа үүсэх үйл явц юм.
- Давхраажилтыг үүсгэж байгаа тэгш бус байдлын хэлбэрүүд нийгмийн хөгжлийн үе шат бүрт харилцан адилгүй байсаар иржээ.
- Нийгмийн анги бүлгүүд өмч хөрөнгө, эрх мэдэл, нэр хүндээрээ нэг нь нөгөөгийнхөө дээр юмуу доор байрлах байдлыг нийгмийн давхраажил гэнэ. Тэр нь нийгмийн бүлгүүдийн нийгэмд эзлэх байр суурь, эрх мэдэл тэгш биш болохыг илтгэнэ.
- Нийгэмд эхлээд тодорхой ялгаатай явцуу хүрээ, дараа нь үе давхраа, эцэст нь ангиуд үүсчээ.



Нийгмийн давхраажилт

Давхраажилтын хэмжигдэхүүн:

1. Эд баялаг, орлого- Тодорхой хугацаанд хувь хүн юмуу гэр бүлийн олж байгаа мөнгөний тоо хэмжээ. \цалин, тэтгэвэр, шагнал зэрэг олж байгаа мөнгөн ашгийн нийлбэр дүн\
2. Боловсрол, мэргэжил- Хүний олж авсан мэдлэг нь орчин үеийн оюунлаг, мэдээллийн нийгэмд улам их үүрэг гүйцэтгэх болсон. Мөн зохих онолын болон практик бэлтгэл бүхий хүний үйл ажиллагааны төрөл.
3. Нэр хүнд- Албан тушаал, ажил мэргэжил, авъяас чадварт өгч байгаа нийгмийн санаа бодлын хүндлэл.
4. Эрх мэдэл- Хүсэл зорилгоо хэрэгжүүлэх арга, чадвар, боломж юм.



Нийгмийн давхраажилт

Давхраажилтын хэв маягууд:


- 1. Боолын хэв маяг-** Тэгш бус байдлын туйл болсон , хүний эрх мэдлээр бүрэн хязгаарласан , хүнийг мөлжих нийгэм , эдийн засаг хууль зүйн хэлбэр юм . Уламжлалт гэрийн боолчлол буюу энгийн хэлбэр , боловсронгуй хэлбэр буюу сонгодог хэлбэр гэж хоёр хувааж үздэг
- 2. Кастын хэв маяг-** Үндсэн суурь нь шашны ёс журам , зан үйлээр баталгаажсан угсаатны дотоодын ялгаанд оршдог . Нийгэм нь дотроо шатлал бүхий кастад хуваагдах ба дотроо нийгмийн шатлан захирах ёсонд хатуу тогтоосон байр суурь эзэлдэг эрэмбэ бүхий хаалттай бүлэг болдог . Кастын байгуулалын сонгодог жишээ Энэтхэг юм .
- 3. Язгуур угсааны хэв маяг-** Язгуур хэв маяг гэдэг бол нийгэмд гүйцэтгэх үүргийг нь төрөөс хуулиар тогтоож өгсөн байдаг нийгмийн бүлгүүд юм Дундад зууны Европын феодалын язгууруудыг харуулав
- 4. Ангийн хэв маяг-** Орчин үеийн нийгэм дэх бусдаасаа орлого, боловсрол, эрх мэдэл, нэр хүндээрээ ялгаатай аливаа нийгмийн давхрааг анги гэнэ. Орчин үеийн нийгэмд ямар ангиуд байдгийг АНУ - аар жишээлж үзүүлэв.

Угсаатан, түүний хэлбэрүүд

Өөртөө хүмүүсийн анхны нийтлэг болох ураг, овог, аймаг, ястан болон сүүлд бүрэлдэн бий болсон үндсэн гэсэн ойлголтийг өөртөө багтаасан өргөн ойлголт юм.

ОВОГ	Нэг гарал үүсэл, нэг хэл яриа, нийтлэг заншил, шүтлэг соёлтой, цусан холбоо бүхий бүлэг.
АЙМАГ	Овгийг бодвол хэдэн зуугаас хэдэн мянган хүмүүс, хэд хэдэн овгоос бүрдэнэ.
ЯСТАН	Нэг хэл, сэтгэл зүйн онцлог, заншил зан төрх уламжлалтай, нэг газар оршин амьдардаг хүмүүс.
УГСААТАН	Газар нутгийн хүрээ түүхэн ёсоор тогтсон соёл, сэтгэлзүйн ерөнхий шинж онцлогийг хадгалсан, урт удаан хугацааны холбоотой том бүлэг хүмүүсийн тогтвортой цогц юм.
ҮНДЭСТЭН	Тодорхой нутаг дэвсгэрт амьдарч байгаа нэг үндэстнүүдийн угсаатны шинж чанарууд төдийгүй тухайн үндэстэн угсаатнаас өөр үндэстэн угсаатны газар нутаг амьдарч байгаа бүх төлөөлөгчид.

Гэрлэлт





Гэрлэлт

Гэрлэлтийн үндсэн дээр үүссэн хүйсийн болон цусан төрлийн холбоо, аж ахуйн нийтлэгийг гэр бүл гэнэ.

Гэрлэлтийн хэлбэр:

1. Моногами- Нэг эмэгтэй , нэг эрэгтэй хоорондоо гэрлэснийг
2. Полигами- Бүлгийн буюу олон эхнэртэй (нөхөр) -тэй гэр бүл
3. Полигени- Нэг эрэгтэй олон эхнэртэй байх
4. Полиандри- Нэг эмэгтэй олон нөхөртэй байх

Ханиа сонгох:

1. Эндогами- Нэг бүлгээс үл хамаарах гэрлэлт
2. Экзогами- Нэг бүлэг дотроосоо гэрлэх.



Гэрлэлт

Цул \энгийн\ гэр бүл- Эцэг эх үр хүүхдийн хамт амьдарч буй гэр бүл
Өрөөсгөл гэр бүл- Салсан бэлбэсэрсэн , хүүхэдгүй гэр бүл
Өргөжсөн гэр бүл- Эцэг эх хүүхдээс гадна өвөө , эмээ , ач , зээ , үеэл
ах дүү нарын хамт амьдарч буй гэр бүл.

Гэр бүлийн нийгэм дэх үүрэг:

- Удам угсаа залгамжлах
- Үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх
- Нийгмийн үнэт чанар, уламжлалыг хадгалах, хөгжүүлэх, өвлүүлэх
- Гэр бүлийн гишүүд бие биенээ асарч халамжлах , эрүүл байлгах
- Гэр бүлийн аж ахуй эрхэлж , санхүүгийн хангамжаа сайжруулах
- Гадны сөрөг хүчин зүйлүүдээс хамгаалах , нийгэмд хяналт тавих

Хяналтын асуулт, даалгавар:

1. Үгсийг төрөлх болон олдмол статусаар ангилах: 18 настай, эрэгтэй, Батын Дорж, Монгол хүн, 12А анги, Ах болон эгч, спортын мастер, найз, монголоор ярьдаг.


Төрөлх статус	Олдмол статус
....

2. Нийгмийн байр суурь, статусын талаарх зөв бодомжуудыг олно уу?
- А. Нийгмийн байр суурь нь нийгмийн бүтцийн микро тал
 - В. Статус бол тухайн нийгмийн тогтолцоонд хувь хүний эзлэх байр суурь, түүнд хамаарах эрх, үүргийн цогц
 - С. Хүмүүсийн нийгмийн байр суурь ижил бөгөөд өөрчлөгддөггүй
 - D. А ба В зөв
 - E. Бүгд буруу

Мэргэн ухаанаас гурван онцлог төрөн гардаг.
Тэд бол зөв шийдвэр гаргах, алдаагүй ярих,
хийх ёстой зүйлээ хийх. \Демократ\

Эх сурвалж:

1. “Нийгэм судлал” хичээлийн ерөнхий боловсролын сурах бичгүүд
2. Д.Буян “Нийгмийн тухай мэдлэг”. УБ., 2011
3. Орчуулсан Б.Батчулуун “Философи”. УБ., 2012
4. О.Пүрэв, С.Нямзагд, Р.Дарьхүү, Г.Сайнхишиг, Д.Буян, Т.Алтанцэцэг “Нийгмийн ухаан”. УБ., 2012
5. Б.Амгаланбаяр, Т.Сайхнаа “Хичээлүүдийн лавлах”. УБ., 2014



Анхаарал хандуулсанд баярлалаа.

